

Аудитын код: САГ-2018/62/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn


Аудитор С.Энхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: enkhtuyas@audit.gov.mn

Гэрээт аудитор Э.Ундармаа
Утас: 261740 Цахим хаяг: undarmaae@audit.gov.mn



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	АУДИТЫН ТАЙЛАН	1
2.1.	ОРШИЛ	1
2.2	АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА...	1
2.3	БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	2
2.4	АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН	2
2.5	ДОТООД ХЯНАЛТ	3
2.6	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА.....	3
2.7.	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ.....	3
2.8.	ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТООЦСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	3
2.9.	АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ	4
2.9.1.	Хөрөнгийн талаар:	4
2.9.2.	Авлагын талаар :	4
2.9.3.	Төсвийн зарцуулалтын талаар	4
2.9.4.	Санхүүгийн тайлагналын талаар.....	5
2.10.	АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	5
2.11.	ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД.....	6
2.12.	ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	6
2.13.	МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:	6
2.14.	САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ.....	6
3.	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	7
3.1.	АВЛАГЫН ТАЛААР	8
3.2.	ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР	9
3.3.	САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР	10
4.	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	11
4.1.	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	11
4.2.	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	13
4.3.	АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	15
4.4.	АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	16
4.5.	АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	18





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Ө.ЭНХТӨР ТАНАА

2018.02.23 № 06/442
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0223SAG39.Docx


070435

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1. ОРШИЛ

Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хууль сахиулахын их сургуулийн захирал, Цагдаагийн хурандаа Ө.Энхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд эзэн холбогдогчгүй авлагыг эрх бүхий байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүгийн тайланг ямар нэгэн орхигдуулалгүй үнэн зөв бэлтгэж, тайлагнах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 5-наас 2018 оны 2 дугаар сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хууль сахиулахын их сургуулийн 2018 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 6/191 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хууль сахиулахын их сургууль санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 73 дугаар зүйлийн 73.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/278 дугаар тушаалыг үндэслэн Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2017 оны 12 дүгээр сарын 12-ны өдрийн Б/682 дугаар тушаалаар Хууль сахиулахын их сургуулийн албан тушаал, орон тоог баталсан ба 455 орон тоотой байхаар баталсан байна.

Үйл ажиллагааны зорилго:

- Хууль сахиулахын ажлын инновацийн үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх,
- Мэргэжлийн болон өндөр боловсрол, мэдлэгтэй, төрийн тусгай албаны шилмэл бүрэлдэхүүнийг бэлтгэх,
- Хууль сахиулахын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Тус байгууллага нь дээрх зорилгын хүрээнд 2017 онд дараах зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтийг нь хангаж ажилласан байна. Үүнд:

- Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, Их сургуулийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх,
- Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулах,
- Гадаад дотоодын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- Хууль зүйн салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Соён гэгээрүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх,
- Бие бүрэлдэхүүний ажиллаж, суралцах таатай орчин бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

Хууль сахиулахын их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 13 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

САГ-2018/62/СТА-ТШЗ

Хууль сахиулахын их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Хууль сахиулахын их сургууль нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” программ хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналт “дунд” байна гэж үзлээ.

2017 онд Хууль сахиулахын их сургууль нь 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2017 онд Хууль сахиулахын их сургуулийн Дотоод аудитын албанаас Санхүү төлөвлөлтийн албанд 2 чиглэлээр хэсэгчилсэн шалгалт хийж 9 зөрчил илрүүлж, 6 зөвлөмж өгч ажилласан байна.

2.6 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Хууль сахиулахын их сургууль 5 чиглэлээр хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 11,110,351.1 мянган төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 11,094,919.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Тайлант онд батлагдсан төсөвт зардлыг 0.1 хувиар буюу 15,431.8 мянган төгрөгөөр хэмнэжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 313,963.1 мянган төгрөг буюу 54.7 хувиар давж биелсэн байна.

Батлагдсан төсөвт зардлыг зардлын зүйл анги бүрээр хэмнэж ажилласан байна.

2.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль сахиулахын их сургууль шилэн дансанд байршуулах мэдээллээ Шилэн данс нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn>, байгууллагын цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбараар бүх мэдээллээ хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

2017 онд өөрийн байгууллагын цахим хуудас болон нэгдсэн цахим хуудасны “Төсөв/гүйцэтгэл”, “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” зэрэг бүх мэдээллүүдийг байршуулан, улирлын тайлангаа ТЕЗ-ын дотоод аудитын албанд сар бүр илгээж хэвшсэн, УАГ-аас 2017 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн Нийцлийн аудитад хамрагдаагүй байна.

2.8. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТООЦСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын эрсдэлийг 25 чиглэлээр тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9. АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ, ГАРГАСАН ШИЙДЭЛ

2.9.1. Хөрөнгийн талаар:

2017 оны 11 сард Хил хамгаалах ерөнхий газраас ирүүлсэн 106,157.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 693.5 мянган төгрөгийн бараа материалыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүй, зөвхөн ХХЕГ-ын даргын шийдвэртэй ирсэн тул байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэж, тайлагнаагүй байгаа нь хөрөнгө дутагдах, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт сулрах эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалт зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: ХХЕГ-аас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн холбогдох баримт материалыг бүрдүүлэн 2018 оны 1 дүгээр улиралд багтаан үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, бүртгэж тайлагнах.

2.9.2. Авлагын талаар :

Өмнөх оноос дамжиж ирсэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 27,932.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан ба уг авлагыг барагдуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн боловч тодорхой шийдвэр гараагүй байна.

2012 -2016 оны хооронд Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 34 цэргийн албан хаагчид олгосон тэтгэмжийн 611,620.6 мянган төгрөгийн урьдчилгааг тухайн тайлант онуудад шууд зардалд бичин хаасан ба урьдчилгаа дансны үлдэгдлээр бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, авлага, өглөгийн гүйлгээг буруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: 1.Эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх, 2.Тэтгэмжийн урьдчилгааг дахин нягтлан тооцож, холбогдох данс олон санхүүгийн тайланд залруулга хийж бүртгэх.

2.9.3. Төсвийн зарцуулалтын талаар

а) Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 10,784.4 мянган төгрөгийн шуудан холбооны зардалд, 11,613.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 4,009.5 мянган төгрөгийн томилолт зочны зардал, Багаж тоног төхөөрөмжийн зардлаас бараа материалд 3,999.9 мянга, кабинет тохижуулах зардал 16,460.0 мянга, Хичээл үйлдвэрлэлийн зардлаас лаборатори байгуулах зардалд 33,499.3 мянга, Тэтгэмж урамшууллын зардлаас томилолт, зочны зардалд 1,765.0 мянга, хурлын материал бэлтгэхэд 1,160.0 мянга, ахмадын санд дэмжлэг 10,000.0 мянган төгрөгийн зардлыг тус тус бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан.

б) Багаж тоног төхөөрөмжийн зардлаас 120,449.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.

в) ХСИС-ийн 3 ажилтны ээлжийн амралтыг ажлын шаардлагаар биеэр эдлүүлээгүй тул Хөдөлмөрийн хуулийн дагуу ээлжийн амралтын цалинг 1.5 хувиар нэмэгдүүлэн тооцож олгохдоо 1,963.6 мянган төгрөгийг илүү, 2017 онд сахилгын арга хэмжээ авагдсан 1 ажилтанд 300.0 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны батлагдсан төсөвт зардлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.4. Санхүүгийн тайлагналын талаар

Үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн 8,247.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн бүртгэхдээ үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгөөр бүртгэсэн боловч бараа материалыг данснаас хассан бичилтийг нь орхигдүүлсан.

Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн жилийн эцсийн үлдэгдэл үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн эцсийн үлдэгдлээс 987.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийв.

2.10. АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

а) Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т "Цэргийн албан хаагчийн 1 удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх үүссэнээс хойш үргэлжлүүлэн алба хааж байгаа офицер, ахлагчид өөрийн нь хүссэнээр цэргийн чөлөөлөгдөхөөс өмнө урьдчилан олгож болно" гэж заасны дагуу Хууль сахиулахын их сургуулийн хэмжээнд ажиллаж байгаа тэтгэврийн насны 41 албан тушаалтанд 2012-2017 онуудад нийт 761,779.6 мянган төгрөгийн 18 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийн урьдчилгаа олгож, суутган тооцоогүй байна.

Дээр дурьдсан Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан зүйл нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д "Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно", Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 10 дугаар зүйлд "Өндөр насны тэтгэврээ албан ёсоор тогтоолгож, ажил олгогчид өргөдөл гаргасных нь дараа энэ журамд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно" гэсэн заалтуудтай зөрчилдөж байна. Иймд эдгээр хуулиудын зөрчигдөж буй заалтуудын талаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжлах.

б) Монгол Улсын Засгийн газраас 2015 онд "Хууль сахиулахын их сургуулийн албан хаагчдын төрийн тусгай алба хаасан хугацааны, албан ажлын онцгой нөхцлийн, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг цагдаагийн албан хаагчдад олгож байгаа нэмэгдлийн хувь хэмжээтэй адилтган тооцон олгож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт суутгаж байх" тухай 240 дүгээр тогтоол гарсан боловч тус тогтоол хэрэгжихгүй байгаа хүсэлтийг аудитын явцад аудитын багт ирүүлсэн тул Хууль зүй, дотоод хэргийн сайд болон холбогдох байгууллагад уламжилж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Цагдаа, цэргийн байгууллагуудын албан хаагчдад урьдчилгаа хэлбэрээр Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Цэргийн албан хаагчийн 1 удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх үүссэнээс хойш үргэлжлүүлэн алба хааж байгаа офицер, ахлагчид өөрийн нь хүссэнээр цэргийн чөлөөлөгдөхөөс өмнө урьдчилан олгож болно” гэж заасны дагуу олгосон тэтгэвэр тэтгэмжийн урьдчилгааны бүртгэл, суутган тооцооллын давтан аудит хийх шаардлагатай гэж үзлээ.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Хууль сахиулахын их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 5 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 5 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

2.13. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 11,874,032.1 мянган төгрөг бөгөөд 2.0 хувиар буюу 237,480.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.14. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хууль сахиулахын их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1. АВЛАГЫН ТАЛААР**ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1****ҮАГ-ын ажиглалт**

Өмнөх оноос дамжиж ирсэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 27,932.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан ба уг авлагыг барагдуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн боловч тодорхой шийдвэр гараагүй,

2012-2016 оны хооронд Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 34 цэргийн албан хаагчид олгосон тэтгэмжийн 611,620.6 мянган төгрөгийн урьдчилгааг тухайн тайлант онуудад шууд зардалд бичин хаасан ба урьдчилгаа дансны үлдэгдлээр бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, авлага, өглөгийн гүйлгээг буруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулиудын холбогдох заалтууд болон санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд тус тус зөрчигдөх;
Хөрөнгө үргүй зарцуулагдах, давхар олгогдох.

ҮАГ-ын зөвлөмж

Эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх,

Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн урьдчилгаа авсан 34 цэргийн албан хаагчдын 611,620.6 мянган төгрөгийн урьдчилгааг дахин нягталж, холбогдох данс болон санхүүгийн тайланд нөхөж бүртгэн, тайлагнах,

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дүгээр сарын 20-ны дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.2. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР**ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2****ҮАГ-ын ажиглалт**

Батлагдсан төсөвт зардлаас нийт 213,740.8 мянган төгрөгийн зардлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан,

ХСИС-ийн 3 ажилтны биеэр эдлээгүй ээлжийн амралтыг цалинг 1.5 хувиар нэмэгдүүлэн тооцож олгохдоо 1,963.6 мянган төгрөгийг илүү, 2017 онд сахилгын арга хэмжээ авагдсан 1 ажилтанд 300.0 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсөвт зардлын холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар шилжүүлэн зарцуулж байх,

Цалин хөлсний тооцоог үнэн зөв тооцож олгох.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дүгээр сарын 20-ны дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгийн ашиглал бий болгох

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3. САНХҮҮГИЙН ТАЛААР	ТАЙЛАГНАЛЫН	ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №3
------------------------	-------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн 8,247.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн бүртгэхдээ үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгөөр бүртгэсэн боловч бараа материалыг данснаас хассан бичилтийг нь орхигдүүлсан,

Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн жилийн эцсийн үлдэгдэл үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн эцсийн үлдэгдлээс 987.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэснийг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд болон НББОУС, СТОУС- ууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Санхүү хангамж, хангалт үйлчилгээний төвийн үйл ажиллагааны хэлбэрийг тодорхой болгож, төсвийн шууд захирагчийн хэлбэрээр эсвэл агуулахын зориулалтаар ажиллуулах талаар холбогдох шийдвэрийг гаргуулан холбогдох хууль, стандартыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дүгээр сарын 20-ны дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,651,220,827.63	2,190,534,667.10
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	21,821.80	21,121.80
Банкинд байгаа бэлэн мөнгө	21,821.80	21,121.80
Төгрөг	21,821.80	21,121.80
Арилжааны банк дахь харилцах	21,821.80	21,121.80
АВЛАГА	27,932,424.00	27,932,424.00
Бусад авлага	27,932,424.00	27,932,424.00
Байгууллагаас авах авлага	10,250,000.00	10,250,000.00
Хувь хүмүүсээс авах авлага	17,682,424.00	17,682,424.00
УРЬДЧИЛГАА		186,533,922.00
Урьдчилж гарсан зардал		186,533,922.00
БАРАА МАТЕРИАЛ	1,623,266,581.00	1,976,047,199.30
Түүхий эд материал	407,898,399.95	453,131,330.20
Тусгай зориулалттай материал	403,846,539.95	435,723,749.10
Эм боох материал	4,051,860.00	17,407,581.10
Бэлэн бүтээгдэхүүн	281,958,336.51	333,863,736.51
Хангамжийн материал	933,409,845.37	1,189,052,132.59
Бичиг хэргийн материал	45,471,951.69	79,308,602.84
Аж ахуйн материал	451,779,843.90	610,939,435.75
Сэлбэг хэрэгсэл	9,391,100.00	19,536,728.20
Түлш шатах тослох материал	20,216,505.25	9,651,654.25
Барилгын засварын материал	85,566,233.00	206,083,836.50
Хүнсний материал	207,325,603.93	162,793,889.65
Бусад хангамжийн материал	113,658,607.60	100,737,985.40
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,171,387,133.43	45,574,339,042.56
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	46,171,387,133.43	45,574,339,042.56
Биет хөрөнгө	46,144,944,841.79	45,558,089,667.63
Барилга, байгууламж	47,797,998,231.90	47,869,638,631.90
Хуримтлагдсан элэгдэл	(4,750,906,530.96)	(5,695,816,619.28)
Авто тээврийн хэрэгсэл	678,538,214.00	716,670,532.00
Хуримтлагдсан элэгдэл	(519,444,581.11)	(605,558,755.62)
Машин тоног төхөөрөмж	1,769,705,102.24	1,965,818,769.47
Хуримтлагдсан элэгдэл	(1,047,080,325.50)	(1,237,412,658.54)
Тавилга, эд хогшил	1,721,810,790.38	2,083,751,928.60
Хуримтлагдсан элэгдэл	(546,249,509.23)	(735,973,199.94)
Батлан хамгаалахын зориулалттай үндсэн хөрөнгө	313,207,136.00	311,157,936.00
Хуримтлагдсан элэгдэл	(26,285,486.00)	(22,736,286.00)
Бусад үндсэн хөрөнгө	680,974,818.35	494,398,518.35
Хуримтлагдсан элэгдэл	(359,628,434.17)	(156,368,337.16)
Номын фонд	432,805,413.89	432,805,413.89
Биет бус хөрөнгө	26,442,291.64	16,249,374.93
Програм хангамж	73,477,060.00	55,664,060.00
Хасагдуулга	(47,031,768.36)	(39,414,685.07)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	47,822,607,961.06	47,764,873,709.66
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	47,822,607,961.06	47,764,873,709.66
Засгийн газрын хувь оролцоо	47,822,607,961.06	47,764,873,709.66
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,588,860,843.91	5,588,860,843.91
Өмч: - төрийн	5,588,860,843.91	5,588,860,843.91
Хуримтлагдсан үр дүн	37,128,638,629.65	37,070,904,378.25
Өмнөх үеийн үр дүн	37,128,638,629.65	37,133,567,029.65

Тайлант үеийн үр дүн		(62,662,651.40)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,105,108,487.50	5,105,108,487.50
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	47,822,607,961.06	47,764,873,709.66



4.2. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,429,359,769.00	11,823,681,961.08
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,124,485,969.00	1,273,165,861.08
Нийтлэг татварын бус орлого	1,124,485,969.00	1,273,165,861.08
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	314,037,560.00	740,378,380.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	307,659,994.00	211,728,639.00
Үнэ төлбөргүй ирсэн материал	35,165,358.00	12,694,084.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	467,623,057.00	308,364,758.08
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,304,873,800.00	10,550,516,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	15,256,072,300.00	10,536,201,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,374,672,300.00	10,536,201,100.00
Хөрөнгийн санхүүжилт	4,881,400,000.00	
Нэмэлт санхүүжилтийн орлого	48,801,500.00	14,315,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,040,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,801,500.00	9,275,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,194,597,040.21	11,874,032,112.36
УРСГАЛ ЗАРДАЛ	10,148,004,577.57	11,133,076,723.99
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,148,004,577.57	11,133,076,723.99
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,941,790,331.00	6,158,244,706.00
Үндсэн цалин	3,515,542,491.00	4,109,778,768.00
Нэмэгдэл цалин	2,181,606,040.00	1,836,373,938.00
Унаа хоолны хөнгөлөлт	218,123,500.00	212,092,000.00
Урамшуулал	26,518,300.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,516,156.00	179,793,110.00
Тэтгэврийн даатгал	62,059,500.00	32,145,900.00
Тэтгэмжийн даатгал	6,770,300.00	4,592,200.00
ҮОМШӨ-ний даатгал	7,334,300.00	3,673,900.00
Ажилгүйдлийн даатгал	1,424,200.00	918,400.00
Эрүүл мэндийн даатгал	91,927,856.00	138,462,710.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	557,897,744.05	560,364,297.04
Гэрэл цахилгааны зардал	206,370,577.00	257,592,237.00
Түлш, халаалтын зардал	145,356,766.05	214,913,121.22
Цэвэр, бохир усны зардал	206,170,401.00	87,858,938.82
Хангамж, бараа материалын зардал	334,279,595.07	268,792,151.77
Бичиг хэрэг	113,134,989.95	105,535,438.85
Тээвэр, шатахуун	62,688,472.00	74,873,851.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	34,403,304.70	27,229,425.77
Ном, хэвлэлийн зардал	7,476,000.00	18,611,560.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	52,168,205.72	26,503,998.15
Бараа материал актласны зардал	74,468,422.70	19,037,878.00
Нормативт зардал	1,732,328,002.36	1,668,522,363.73
Эм	11,110,506.85	21,564,938.90
Хоол	817,717,981.01	873,942,726.33
Нормын хувцас, зөөлөн эдлэл	903,499,514.50	773,014,698.50
Эд хогшил, урсгал засварын зардал	365,517,512.00	273,367,685.60
Багаж хэрэгсэл		359,900.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		12,430,575.80
Урсгал засвар	365,517,512.00	260,577,209.80
Томилолт, зочны зардал	10,074,600.00	22,047,196.00

Дотоод албан томилолт	10,074,600.00	22,047,196.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,000,130.00	129,157,357.02
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,405,350.00	106,887,069.02
Даатгалын үйлчилгээ	9,123,100.00	9,023,188.00
Тээврийн хэрэгсэлийн татвар	2,753,200.00	2,725,700.00
Тээврийн хэрэгсэлийн оношлогоо	363,580.00	290,300.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,313,400.00	10,195,400.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	41,500.00	35,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	964,600,507.09	1,872,787,856.83
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	228,798,334.50	300,403,288.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,178,000.00	19,084,300.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	729,624,172.59	1,553,300,268.83
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,046,592,462.64	740,955,388.37
Бусад урсгал шилжүүлэг	667,473,957.73	692,996,282.20
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	96,940,221.93	160,812,106.40
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	186,747,565.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	372,393,867.00	364,719,992.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,392,303.80	167,464,183.80
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	379,118,504.91	47,959,106.17
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		47,959,106.17
Төвлөрүүлэх шилжүүлэг	379,118,504.91	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,234,762,728.79	(50,350,151.28)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		12,312,500.12
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		12,312,500.12
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI-IV-V)		(12,312,500.12)
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,234,762,728.79	(62,662,651.40)



4.3. АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	14,495,254,231.93	25,189,223,563.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	14,495,254,231.93	25,189,223,563.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	17,402,249,302.26	17,402,249,302.26
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	37,128,638,629.65	47,822,607,961.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,928,400.00	4,928,400.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	37,133,567,029.65	47,827,536,361.06
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-62,662,651.40	-62,662,651.40
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,588,860,843.91	5,105,108,487.50	37,070,904,378.25	47,764,873,709.66



4.4. АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	15,927,250,954.00	11,438,664,194.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	622,377,154.00	888,148,094.00
Нийтлэг татварын бус орлого	622,377,154.00	888,148,094.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	622,377,154.00	888,148,094.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	314,717,160.00	740,378,380.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	307,659,994.00	147,769,714.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,304,873,800.00	10,550,516,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	15,256,072,300.00	10,536,201,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,374,672,300.00	10,536,201,100.00
Хөрөнгийн санхүүжилт	4,881,400,000.00	
Нэмэлт санхүүжилтийн орлого	48,801,500.00	14,315,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,040,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,801,500.00	9,275,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,485,485,884.00	10,778,464,974.00
УРСГАЛ ЗАРДАЛ	10,485,485,884.00	10,778,464,974.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,374,632,836.09	9,911,450,805.83
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,941,790,331.00	6,158,244,706.00
Үндсэн цалин	3,757,946,800.00	4,058,730,906.00
Нэмэгдэл	1,809,669,131.00	1,864,725,400.00
Унаа хоолны хөнгөлөлт	245,740,000.00	234,788,400.00
Гэрээт ажлын хөлс	128,434,400.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,516,156.00	179,793,110.00
Тэтгэврийн даатгал	62,059,500.00	32,145,900.00
Тэтгэмжийн даатгал	6,770,300.00	4,592,200.00
ҮОМШӨ-ний даатгал	7,334,300.00	3,673,900.00
Ажилгүйдлийн даатгал	1,424,200.00	918,400.00
Эрүүл мэндийн даатгал	91,927,856.00	138,462,710.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	557,897,744.05	567,007,967.04
Гэрэл, цахилгааны зардал	206,370,577.00	257,592,237.00
Түлш халаалтын зардал	145,356,766.05	214,913,121.22
Цэвэр бохир усны зардал	206,170,401.00	94,502,608.82
Хангамж, бараа материалын зардал	165,905,815.94	167,627,998.77
Бичиг хэрэг	17,096,320.00	22,643,480.00
Тээвэр, шатахуун	80,020,600.00	68,616,125.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	24,403,304.70	24,229,425.77
Ном, хэвлэл	7,476,000.00	19,299,560.00
Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,909,591.24	32,839,408.00
Нормативт зардал	1,594,138,978.60	1,738,835,293.50
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,591,199.00	35,358,400.00
Хоол, хүнс	688,709,508.16	827,817,497.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	893,845,271.50	875,664,396.50
Эд хогшил, урсгал засварын зардал	418,215,623.00	468,897,172.50
Багаж, техник хэрэгсэл	8,138,999.00	38,608,782.00
Тавилга	1,070,000.00	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	21,697,999.00	57,541,473.00
Урсгал засвар	387,308,625.00	372,746,917.50
Томилолт, зочны зардал	10,074,600.00	22,047,196.00
Дотоод албан томилолт	10,074,600.00	22,047,196.00

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,294,415.00	178,767,746.02
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,661,900.00	118,409,208.02
Даатгалын үйлчилгээ	9,123,100.00	9,023,188.00
Тээврийн хэрэгслийн татвар	2,753,200.00	2,725,700.00
Тээврийн хэрэгслийн оншилгоо	293,200.00	290,300.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	47,421,515.00	48,283,650.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	41,500.00	35,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	406,799,172.50	430,229,616.00
Бараа үйлчилгээний бусад зардал	7,983,500.00	19,622,900.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	398,815,672.50	410,606,716.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,110,853,047.91	867,014,168.17
Бусад урсгал шилжүүлэг	731,734,543.00	819,055,062.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	56,928,747.00	156,875,980.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	197,934,565.00	
Тэтгэврт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	476,871,231.00	514,879,082.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		147,300,000.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	379,118,504.91	47,959,106.17
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		47,959,106.17
Төвлөрүүлэх шилжүүлэг	379,118,504.91	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,441,765,070.00	660,199,220.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,441,761,070.00	660,199,920.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,441,761,070.00	660,199,920.00
Дотоод эх үүсвэрээр	5,441,761,070.00	660,199,920.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,441,761,070.00	660,199,920.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,441,761,070.00)	(660,199,920.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,000.00	(700.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,821.80	21,821.80
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,821.80	21,121.80



4.5. АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,821.80	-21,821.80	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,110,351,100.00	11,390,670,087.83	-280,318,987.83	102.5
УРСГАЛ ЗАРДАЛ	11,110,351,100.00	11,390,670,087.83	-280,318,987.83	102.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,362,451,100.00	10,571,615,025.83	-209,163,925.83	102.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,158,894,200.00	6,158,244,706.00	649,494.00	100.0
Үндсэн цалин	4,059,380,400.00	4,058,730,906.00	649,494.00	100.0
Нэмэгдэл	1,864,725,400.00	1,864,725,400.00		100.0
Унаа хоол болон бусад нөхөн олговор	234,788,400.00	234,788,400.00		100.0
Ажил олгогчоос нийгмийн	191,561,700.00	179,793,110.00	11,768,590.00	93.9
Тэтгэврийн даатгал	32,145,900.00	32,145,900.00		100.0
Тэтгэмжийн даатгал	4,592,200.00	4,592,200.00		100.0
ҮОМШӨ-ний даатгал	3,673,900.00	3,673,900.00		100.0
Ажилгүйдэлийн даатгал	918,400.00	918,400.00		100.0
Эрүүл мэндийн даатгал	150,231,300.00	138,462,710.00	11,768,590.00	92.2
Байр ашиглалттай холбоотой	567,980,300.00	567,007,967.04	972,332.96	99.8
Гэрэл цахилгаан	258,452,800.00	257,592,237.00	860,563.00	99.7
Түлш, халаалт	214,928,500.00	214,913,121.22	15,378.78	100.0
Цэвэр, бохир ус	94,599,000.00	94,502,608.82	96,391.18	99.9
Хангамж, бараа материалын зардал	284,840,800.00	287,443,198.77	-2,602,398.77	100.9
Бичиг хэрэг	19,843,800.00	22,643,480.00	-2,799,680.00	114.1
Тээвэр, шатахуун	68,616,900.00	68,616,125.00	775	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,231,800.00	24,229,425.77	2,374.23	100.0
Ном, хэвлэл	139,303,000.00	139,114,760.00	188,240.00	99.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	32,845,300.00	32,839,408.00	5,892.00	100.0
Нормативт зардал	1,732,597,900.00	1,738,835,293.50	-6,237,393.50	100.4
Эм бэлдмэл, эмнэлэгийн	35,353,400.00	35,353,400.00		100.0
Хоол, хүнс	821,433,500.00	827,817,497.00	-6,383,997.00	100.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	875,811,000.00	875,664,386.50	146,603.50	100.0
Эд хогшил, урсгал засварын	822,529,600.00	935,571,692.50	-113,042,092.50	113.7
Багаж, техник хэрэгсэл	305,488,100.00	366,040,662.00	-60,552,562.00	119.8
Хөдөлмөр хамгааллын	104,116,700.00	104,115,193.00	1,507.00	100.0
Урсгал засвар	412,924,800.00	465,421,837.50	-52,497,037.50	112.7
Томилолт, зочны зардал	21,029,800.00	22,047,196.00	-1,017,396.00	104.8
Гадаад албан томилолт	21,029,800.00	22,047,196.00	-1,017,396.00	104.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	171,089,000.00	221,561,546.02	-50,472,546.02	129.5

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,047,400.00	121,530,808.02	-50,483,408.02	171.1
Даатгалын үйлчилгээ	9,031,900.00	9,023,188.00	8,712.00	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	2,725,700.00	2,725,700.00		100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	290,300.00	290,300.00		100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	87,993,700.00	87,991,550.00	2,150.00	100.0
Бараа үйлчилгээний бусад	411,927,800.00	461,104,316.00	-49,176,516.00	111.9
Бараа үйлчилгээний бусад	20,360,000.00	19,622,900.00	737,100.00	96.4
Хичээл үйлдвэрлэлийн	391,567,800.00	441,481,416.00	-49,913,616.00	112.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	747,900,000.00	819,055,062.00	-71,155,062.00	109.5
Бусад урсгал шилжүүлэг	747,900,000.00	819,055,062.00	-71,155,062.00	109.5
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	85,000,000.00	156,875,980.00	-71,875,980.00	184.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	515,000,000.00	514,879,082.00	120,918.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	147,900,000.00	147,300,000.00	600,000.00	99.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,110,351,100.00	11,438,629,194.00	-328,278,094.00	103.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,536,201,100.00	10,536,201,100.00		100.0
Улсын төсвөөс санхүүжих	10,536,201,100.00	10,536,201,100.00		100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	574,150,000.00	888,113,094.00	-313,963,094.00	154.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	568,250,000.00	740,378,380.00	-172,128,380.00	130.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,900,000.00	147,734,714.00	-141,834,714.00	2504.0
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ		5,040,000.00	-5,040,000.00	
Хандив тусламж		5,040,000.00	-5,040,000.00	
Нэмэлт санхүүжилтийн орлого		9,275,000.00	-9,275,000.00	
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,275,000.00	-9,275,000.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,821.80	-21,821.80	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,121.80	-21,121.80	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ